

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид “шилэн данс” гэх/-г бүрдүүлэхэд оршино.

2 дугаар зүйл.Шилэн дансны тухай хууль тогтоомж

2.1.Шилэн дансны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Дараахь эрх зүйн этгээд, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит нийтийн эрх зүйн хуулийн этгээд:

3.1.1.а.төрийн байгууллага, албан газар;

3.1.1.б.нийтийн байгууллага.

3.1.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд:

3.1.2.а.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

3.1.2.б.хяналтын багцаас бага хэмжээний хувьцааг нь төр болон орон нутгийн өмчит хуулийн этгээд эзэмшиж байгаа улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлдэг том аж ахуйн нэгжийн ангилалд багтдаг, эсхүл төрөөс үйл ажиллагааны татаас, санхүүгийн батлан даалт, олон улсын зээл тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа компани;

3.1.3.Засгийн газар, орон нутгийн тусгай сан,

3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа этгээд;

3.1.5.төрийн чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд.

3.2.Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой ~~мөнгөн болон бусад гүйлгээ~~ мэдээлэл хамаарна:

3.2.1.улс, орон нутгийн төсөв;

3.2.2.орон нутгийн хөгжлийн сан;

3.2.3.Засгийн газар, орон нутгийн тусгай сан;

3.2.4.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа;

3.2.5.Засгийн газар, орон нутгийн өр, авлага үүсгэсэн шийдвэр, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл;

3.2.6.Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;

3.2.7.төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс;

3.2.8.энэ хуулийн 3.2.6-д зааснаас бусад тусламж, хандив.

3.2.9.хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

3.3.Төрийн болон албаны нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ хуульд хамаарахгүй.

3.4.Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно.

3.5.Энэ хуулийн 6 дугаар зүйлд тусгайлан заагаагүй, бусад хууль тогтоомжоор хориглоогүй энэ хуулийн 3.2-т хамаарах мэдээллийг нээлттэй мэдээлж болно.

4 дүгээр зүйл.Шилэн дансны зарчим

4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;

4.1.2.мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;

4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;

4.1.4.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ШИЛЭН ДАНСНЫ СТАНДАРТ

5 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэр

5.1. Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1. шилэн дансны бие даасан цэстэй байх;

5.1.2. мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх;

5.1.3. тодруулга өгөх албан тушаалтны нэр, харилцах утас, цахим хаягийг байршуулсан байх;

5.1.4. мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.

5.2. Шилэн дансны мэдээллийг дуу болон дүрс бичлэгийн хэлбэрээр байршуулж болно.

5.3. Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шилэн дансны нэгдсэн цахим хуудастай байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө.

5.4. Энэ хуулийн 5.1, 5.3-т заасан цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ~~саналыг үндэслэн Засгийн газар~~ батална.

5.5. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна.

5.6. Энэ хуулийн 3.2.5-3.2.8-д заасантай холбоотой шийдвэр шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршсанаар хүчин төгөлдөр болно.

5.7. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.

5.8. Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл

6.1. Энэ хуулийн 3.1.1, 3.1.3-т заасан байгууллага, албан тушаалтан тухайн жилийн батлагдсан төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлтийн талаарх дараахь мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлнэ:

6.1.1. Улсын Их Хурал болон тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголыг батлагдсанаас хойш долоо хоногийн дотор;

6.1.2.Улсын болон аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

6.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

6.1.4.батлагдсан төсвийн эх үүсвэр, орлого, зарлагыг дэлгэрэнгүй ангиллаар жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

6.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

6.1.6.орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

6.1.7.тусгай сангийн эх үүсвэр, зарцуулалтын батлагдсан дүнг батлагдасанаас хойш долоо хоногийн дотор.

6.2.Энэ хуулийн 3.1.1, 3.1.3-т заасан байгууллага, албан тушаалтан тухайн жилийн батлагдсан төсөв болон нэмэлт төсвийн сар, улирлын **гүйцэтгэлийн** талаарх дараахь мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлнэ:

6.2.1.энэ хуулийн 6.1.2-т заасан хөтөлбөрийн биелэлтийг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор;

6.2.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалтыг дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.2.3.мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан хандив, тусламж, түүний зарцуулалт, холбогдох шийдвэрийн хамт хагас жилээр 7 дугаар сарын 25, бүтэн жилээр дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор;

6.2.4.худалдан авах ажиллагааны тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор;

6.2.5.хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийн улирлын мэдээллийг төсөл, объект тус бүрээр дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.2.6.орон нутгийн хөгжлийн сангийн сарын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.2.7.нэмэлт төсвийн орлого, зарцуулалт, түүнтэй холбогдох шийдвэрийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.2.8.тусгай сангаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг улирал бүр дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.2.9.санхүүгийн тайлангаар баталгаажсан өглөг, авлагын дэлгэрэнгүй жагсаалтыг улирал бүр дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.3.Энэ хуулийн 3.1.1, 3.1.3-т заасан байгууллага, албан тушаалтан дор дурдсан мэдээллийг тухайн шийдвэр гарсан, эсхүл үйл ажиллагаа хэрэгжсэнээс хойш долоо хоногийн дотор мэдээлнэ:

6.3.1.тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл, тендерт оролцогчийн нэр, тендер шалгаруулалтын үр дүн, түүний дагуу байгуулсан гэрээ болон гэрээний гүйцэтгэлийн (хэрэгжилтийн) мэдээлэл;

6.3.2.Энэ хуулийн 6.3.1-т зааснаас бусад сонгон шалгаруулалтын үр дүн;

6.3.3.байгууллагын дансны мэдээлэл;

6.3.4.цалингийн зардлаас бусад таван сая төгрөг буюу түүнээс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэл;

6.3.5.таван сая төгрөг буюу түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд холбогдох гэрээ, шийдвэр;

6.3.6.байгууллагын орон тооны мэдээлэл, түүнд орсон өөрчлөлт;

6.3.7.байгууллагын хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэлд орсон өөрчлөлт;

6.3.8.Засгийн газар, орон нутгийн зээл, буцалтгүй тусламж олгосон шийдвэр;

6.3.9.төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ;

6.3.10.төрийн өмчийн эд хөрөнгийг актлах, устгах, шилжүүлэх, шийдвэр, хэлцэл;

~~6.3.11.төсөв зарцуулах эрхээ шилжүүлсэн аливаа шийдвэр;~~

6.3.11.хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь таван сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь таван сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй бол энэ хуулийн 6.3.4-т заасны нэгэн адил мэдээлнэ.

6.4.энэ хуулийн 6.3.4-т заасан мэдээллийг байршуулахаас зайлсхийх зорилгоор үнийн дүнг хэд хэд хуваан гүйлгээ хийхийг хориглоно.

6.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.6-д зааснаас гадна дараахь мэдээллийг мэдээлнэ:

6.5.1.Монгол Улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлбарын хамт дараа сарын 15-ны өдрийн дотор;

6.5.2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг улирал бүр дараа сарын 15-ны өдрийн дотор;

6.5.3.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг төсөл, хөтөлбөр, санхүүжүүлэгч байгууллагаар улирал бүр дараа сарын 15-ны өдрийн дотор;

6.5.4.Засгийн газрын гадаад, дотоод өрийн бүтэц, өрийн хэрэгсэл, өрийн үйлчилгээний мэдээллийг улирал бүр дараа сарын 15-ны өдрийн дотор;

6.5.5.улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоог Үндэсний статистикийн хорооноос улирал бүрийн эдийн засгийн өсөлтийн мэдээг зарласнаас хойш 1 сарын дотор.

6.5.6.Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын байгууллагаас хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор;

6.6.Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.6-д заасан мэдээллээс гадна дараахь мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

6.6.1.концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш;

6.6.2.концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас хойш;

6.6.3.концессын гэрээ байгуулснаас хойш концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл.

6.7.Тухайн шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт, тайлагналын талаар дараахь мэдээллийг мэдээлнэ:

6.7.1.хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 25-ны дотор;

6.7.2.аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын дүгнэлтийн бүрэн эхийн хамт дараа оны 5 дугаар сарын 10-ны дотор;

6.7.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ гарснаас хойш долоо хоногийн дотор;

6.7.3.энэ хуулийн 6.7.2-т заасан аудитын тайлан, дүгнэлт, бусад санхүүгийн хяналт шалгалтын дүнд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хагас жилийн мэдээллийг 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор, бүтэн жилийн мэдээллийг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;

6.8.Энэ хуулийн 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан тухайн жилийн санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөлтийн талаарх дараахь мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлнэ:

6.8.1.тухайн байгууллагын батлагдсан зорилтот түвшингийн мэдээллийг жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор, дараа жилийн зорилтот түвшинг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор;

6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор;

6.8.3.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор;

6.9. Энэ хуулийн 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 6.8-д заасан мэдээллийн гүйцэтгэлтэй холбоотой дараахь мэдээллийг дор дурдсан хугацааны дагуу:

6.9.1.зорилтот түвшний гүйцэтгэлийн улирлын мэдээг дараа сарын 15, хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 25, бүтэн жилийн мэдээг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор;

6.9.2. мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан, олгосон хандив, тусламж, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг холбогдох шийдвэрийн хамт 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор;

6.9.3. худалдан авах ажиллагааны тайланг дараа жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор;

6.9.4. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээллийг улирал бүр дараа сарын 8-ны өдрийн дотор;

6.9.5. улс орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй татварын болон татварын бус орлогын улирлын мэдээг дараа сарын 15, хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 25, бүтэн жилийн мэдээг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор;

6.9.6. өмч, хөрөнгийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт хагас жилээр 7 дугаар сарын 25, бүтэн жилээр дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор;

6.10. Энэ хуулийн 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараахь мэдээллийг тухайн шийдвэр гарсан, үйл ажиллагаа хэрэгжсэнээс хойш долоо хоногийн дотор мэдээлнэ:

6.10.1. тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлт;

6.10.2. байгууллагын хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэлд орсон өөрчлөлт;

6.10.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу гүйцэтгэх тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл, тендер оролцогчийн нэр, тендер шалгаруулалтын үр дүн, түүний дагуу байгуулсан гэрээ болон гэрээний гүйцэтгэлийн (хэрэгжилтийн) мэдээлэл;

6.10.4. энэ хуулийн 6.10.3-т зааснаас бусад сонгон шалгаруулалтын мэдээлэл;

6.10.5. тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7-д заасан шийдвэр;

6.10.6. худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлт;

6.10.7. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтын нэмэлт, өөрчлөлт;

6.10.8. төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн хийсэн их хэмжээний хэлцэл, түүнд тооцогдохуйц баталгаа, батлан даалт;

6.10.9. Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын урамшуулал, цалингийн хэмжээг тогтоосон шийдвэр;

6.11. Энэ хуулийн 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан санхүүгийн хэрэгжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт, тайлагналын талаар дараахь мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

6.11.1. хагас жилийн санхүүгийн тайланг гаргаснаас хойш;

6.11.2. аудит хийсэн жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн бүрэн эхийн хамт хүлээн авснаас хойш;

6.11.3. эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын дүнг хүлээн авснаас хойш;

6.11.4.энэ хуулийн 6.8.4.б, 6.8.4.в-д заасан хяналт шалгалтын дүнгийн хэрэгжилтийг тухайн шийдвэрт тогтоосон хугацаанаас хойш;

~~6.6.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг олон нийтийн цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.~~

6.12.Эрх бүхий этгээд аливаа төсөв, өмч, хөрөнгө зарцуулахтай холбогдох шийдвэр гаргах, гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл үүссэн тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг бичгээр гаргаж 7 хоногийн дотор мэдээлнэ.

6.13.Энэ хуулийн 6.10.3 дахь заалт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулдаг энэ хуулийн 3.1.2-т заасан этгээдэд хамаарна.

7 дугаар зүйл.Мэдээлэх албан тушаалтан

7.1.Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараахь албан тушаалтан хүлээнэ:

7.1.1.Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан;

7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан эрх бүхий албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн албан тушаалтан;

7.1.3.тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

7.3.Энэ хуулийн 3.1 дэх хэсэгт заасан байгууллага шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг өөрийн дотоод зохион байгуулалтын нэгжээр гүйцэтгүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ШИЛЭН ДАНСНЫ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

8 дугаар зүйл.Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт

8.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурлын хяналт тавих үйл ажиллагааны журмыг төрийн аудитын дээд байгууллага боловсруулан баталж мөрдүүлнэ.

8.2.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

8.3.Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно.

8.4.Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно харгалзан үзнэ.

9 дүгээр зүйл.Иргэний хяналт

9.1.Энэ хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно.

9.2.Төрийн аудитын байгууллага нь гомдол, мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тухайн иргэнд бичгээр болон олон нийтэд мэдээлнэ.

9.3.Иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

10 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

11.1.Энэ хуулийг 202... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР